



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 01 сарын 05 өдөр

Дугаар А/14

Мандалговь

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.9, 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дэлхийн Зөн Олон Улсын байгууллагаас хэрэгжүүлж буй “Уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй орон нутаг” төслийг дэмжин хэрэгжүүлэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: М.Анхбаяр (Аймгийн Засаг даргын орлогч)
Гишүүдэд: Н.Эрдэнэ-Очир (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга)
Х.Дашням (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн)
М.Ганчимэг (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн)
Б.Мөнхжаргал (Хөдөө аж ахуйн газрын дарга)
Ц.Гэрэл (Мал эмнэлгийн газрын Мал амьтны эрүүл мэндийн албаны дарга)
Б.Цэрэнням (Онцгой байдлын газрын мэргэжилтэн)
Д.Алтантогос (МОНЦАМЭ агентлагийн Дундговь дахь сурвалжлагч)
Нарийн бичгийн дарга: Д.Мөнхбадрах (Дэлхийн зөн Олон Улсын байгууллагын Дундговь дахь төлөөлөгч)

2. Төслийн үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөл боломжийг бүрдүүлэн, зорилтот сумдыг удирдан чиглүүлж, мэдээллийг улирал тутам танилцуулж ажиллахыг ажлын хэсэг (М.Анхбаяр)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

4823110540